

Хөгжлийн бэрхшээлтэй хүн гэж хэнийг хэлэх вэ?

Бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн согогийн улмаас бусдын адил нийгмийн харилцаанд оролцох чадвар нь бүрэн болон 12 сараас дээш хугацаагаар хязгаарлагдсан хүнийг “хөгжлийн бэрхшээлтэй” гэж ойлгоно.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай ойлголт

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх гэж хууль тогтоомжоор баталгаажигдсан тусгай эрх байдаггүй. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бусдын нэгэн адил иргэний, улс төрийн, эдийн засгийн, нийгмийн, соёлын бүхий л эрхийг алагчлалгүйгээр эдлэх эрхтэй. Харин эдгээр эрхийг бүрэн дүүрэн эдлүүлэх арга зам нь ялгаатай бөгөөд тусгай орчин нөхцөл, хэрэглэгдэхүүн шаардлагатай юм.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэн нь нийгмийн халамж, хамгааллын ямар ямар төрлийн үйлчилгээнд хамрагдах эрхтэй вэ?

- Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж авах
- Нийгмийн халамжийн тэтгэвэр авах
- Нөхцөлт мөнгөн тэтгэмж авах
- Тусламж, хөнгөлөлт эдлэх
- Төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамрагдах
- Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд хамрагдах
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээнд хамрагдах
- Эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдах
- Боловсрол, соёл, урлагийн үйлчилгээнд хамрагдах

16 нас хүрээгүй хүүхдийн хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг ямар байгууллага тогтоох вэ?

- 16 нас хүрээгүй хүүхдийн хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг оршин суугаа аймаг, дүүргийн эрүүл мэндийн байгууллагын мэргэжлийн эмч нарын хяналтын комиссоор тогтоолгоно.
- 16 болон түүнээс дээш насанд хүрсэн иргэний хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг ямар байгууллага тогтоох вэ?
 - Ердийн өвчин, ахуйн ослын улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтсийн дэргэдэх Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс тогтооно.
 - Харин үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг зөвхөн Мэргэжлийн өвчин судлалын төвийн дэргэдэх Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс тогтооно.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэн хөдөлмөр эрхэлж болох уу?

Болно. Хөдөлмөрийн тухай хуульд зааснаар 25, түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага нь ажил, албан тушаалынхаа дөрөв, түүнээс дээш хувийн орон тоонд хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг ажиллуулна.

НИЙСЛЭЛИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ГАЗАР

СОЁЛЫН ТӨВ ӨРТӨВ Г КОРПУС 5 ДАВХАР

УТАС: 7011 0502, 7012 0502, 7013 0502, 7014 0502



ЗАСГИЙН ГАРЫН ХЭРЭЖЛҮҮЛЭГЧ АГЕНТАГ
ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ
— ГАЗАР —



НИЙСЛЭЛИЙН ХӨДӨЛМӨР
ЭРХЛЭЛТИЙН ГАЗАР

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭНИЙ АЖЛЫН БАЙРЫГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР

Жил бүрийн 12 дугаар сарын 03
ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ӨДӨР

Хөдөлмөрийн нэгдсэн лавлах

1800 1896

Энгийн утасны тарифаар



www.ubytj.ub.gov.mn

ЗОРИЛГО:

Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хөдөлмөрт бэлтгэх, дэмжлэгтэйгээр ажилд зуучлах, аж ахуй эрхлэлт болон хөдөлмөр эрхлэх үр чадвар олгох сургалтанд хамруулах, урамшуулал, санхүүгийн дэмжлэг олгох, хөдөлмөр эрхлэлтийн тусгай үйлчилгээ, арга хэмжээнд хамруулж дэмжлэг үзүүлэх замаар хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан байнгын ажлын байрыг нэмэгдүүлэх.

ХАМРАХ ХҮРЭЭ:

- ◆ Хөгжлийн бэрхшээлтэй иргэн
- ◆ Байнгын асаргаанд байдаг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч буй эцэг, эх, асран хамгаалагч
- ◆ Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажлын байраар хангаж буй ажил олгогч

ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГТЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ:

- ◆ Аж ахуй эрхлэлтийн сургалт зохион байгуулах
- ◆ Ажлын байрны түрээсийн дэмжлэг үзүүлэх
- ◆ Ажил олгогчид санхүүгийн дэмжлэг олгох

АЖ АХУЙ ЭРХЛЭЛТИЙН СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ

Санхүүгийн дэмжлэгт хамрагдсан болон бичиг бизнес эрхэлдэг, цаашид эрхлэх хүсэл сонирхолтой хөгжлийн бэрхшээлтэй иргэн, байнгын асаргаанд байдаг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагчийг хүсэлтийн дагуу хамруулна.

Эрх бүхий мэргэшсэн, боломжит тохируулгатай сургалтын орчин бүрдсэн мэргэжлийн эрх бүхий байгууллага, иргэнтэй гэрээ байгуулан 3-5 хоногийн хугацаанд зохион байгуулна.

АЖЛЫН БАЙРНЫ ТҮРЭЭСИЙН ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ

Ажлын байрны түрээсийн хөнгөлөлтөд үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ажлын байр түрээслэн 12 сараас дээш хугацаагаар тасралтгүй үйл ажиллагаа эрхэлсэн хувиараа хөдөлмөр эрхлэгч хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг, мөн нийт гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь хөгжлийн бэрхшээлтэй иргэн байдаг нөхөрлөл, хоршоо, бизнес инкубатор төвийн бийжигчийг хамруулна.

Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газар нь холбогдох баримт бичиг, түрээсийн гэрээг үндэслэн нөхцөл байдлыг газар дээр нь тодорхойлсоны үндсэн дээр ажлын байрны түрээсийн хөнгөлөлтийг нөхөн олгоно. Түрээсийн төлбөрийн хөнгөлөлтийг нөхөн олгохдоо тухайн төлбөрийг төлсөн баримтыг үндэслэнэ.

Ажлын байрны түрээсийн төлбөрийн хөнгөлөлтөд хамрагдсан иргэн, нөхөрлөл, хоршоо, бизнес инкубаторын бийжигч нь 24 сарын хугацаанд энэхүү хөнгөлөлтөд дахин хамрагдахгүй.

АЖИЛ ОЛГОГЧИД САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ ОЛГОХ

Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг 12 сараас доошгүй хугацаагаар байнгын тусгайлсан ажлын байраар хангасан ажил олгогчид хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 12 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний урамшууллыг ажлын байраар хангасан хүний тоогоор олгоно.